



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Зөвлөл шинэчлэн байгуулах, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5 дахь заалт, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Батлан хамгаалахын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Батлан хамгаалахын дэд сайд;

Орлогч дарга:

Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч;

Гишүүд:

Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга;
ямны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
ямны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;
ямны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга;
Зэвсэгт хүчний Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга;
Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга;
Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга;
Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн тэргүүн дэд захирал;

Нарийн бичгийн дарга:

ямны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн.

2. “Батлан хамгаалахын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

3. Салбарын хэмжээнд гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Зөвлөлийн даргад даалгасугай.

1320100425

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2016 оны “Зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” А/350 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Ч.Гандирваа/-т үүрэг болгосугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
0.8 дугаар сарын 19 ны өдрийн
118.0 дугаар тушаалын хавсралт

**БАТЛАН ХАМГААЛАХЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ДЭГ
ЖУРАМ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗӨВЛӨЛИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Батлан хамгаалахын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөл” /цаашид “Зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Зөвлөл нь батлан хамгаалах салбарын хэмжээнд гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, ажлын хариуцлагыг сайжруулах ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, яамны харьяа аж ахуй нэгж байгууллагууд, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг чиглүүлж, яамны удирдлага, “Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-ийг мэдээллээр хангах үүрэгтэй.

1.3. Зөвлөл нь яам, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалуудын төлөөллөөс бүрдсэн, орон тооны бус зөвлөл байна.

1.4. Зөвлөл нь үйл ажиллагаандаа “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” болон бусад холбогдох хууль, тогтоомж, тушаал, шийдвэр, энэхүү журмыг удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь дарга, орлогч дарга, гишүүд, нарийн бичгийн даргатай байна.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.3. Зөвлөл шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тодорхой асуудлаар Ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

2.4. Зөвлөлийн ээлжит хуралдааныг улирал тутам хийнэ. Зөвлөлийн нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг даргын санаачилгаар, эсхүл зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар хуралдуулж болно.

2.5. Хэлэлцэх асуудлаас хамааран холбогдох албан тушаалтнуудыг оролцуулж, өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулж болно.

2.6. Зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг орлогч дарга гүйцэтгэнэ.

2.7. Зөвлөлийн хуралдаанаар гэмт хэрэг, сахилгын /осол/ зөрчлийн нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй ажлын явц, үр дүн, зөвлөлийн сар, жилийн ажлын

тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, салбар зөвлөлүүдэд сахилга, хариуцлагыг бэхжүүлэх талаар зохиож буй ажил, зөвлөлөөс хийсэн шалгалтын дүн, судалгааны ажлын тухай асуудлуудыг хэлэлцэнэ.

2.8. Хэлэлцсэн асуудал, гаргасан саналын зөрүүтэй байдлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар, санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.9. Зөвлөлийн чиг үүргийнхээ хүрээнд хуралдаанаас гаргасан шийдвэр нь зөвлөмж, албан даалгавар хэлбэртэй байна. Шаардлагатай гэж үзвэл зарим асуудлаар сайдын тушаал гаргуулж болно.

2.10. Зөвлөлийн хуралдааныг тэмдэглэл хөтөлж баталгаажуулах бөгөөд түүнд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж албажуулна.

2.11. Хуралдааны явцын тухай дэлгэрэнгүй тэмдэглэлд дор дурдсан зүйлийг заавал тусгана.

- 2.11.1. хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан огноо, цаг, минут;
- 2.11.2. хуралдааны ирц /тоо, хувиар/, оролцоогүй гишүүний нэр, шалтгаан;
- 2.11.3. хэлэлцсэн асуудал, түүнийг танилцуулсан хүний албан тушаал, нэр;
- 2.11.4. хуралдаанаар тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцсон, байлцсан хүмүүсийн албан тушаал, овог нэр;
- 2.11.5. хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт, хариулт, гаргасан санал, шүүмжлэл, хэлсэн үгийн товч утга;
- 2.11.6. санал зөрүүтэй асуудлаар болон гарах шийдвэрийн төслийн талаарх санал хураалтын дүн /тоо, хувиар/;
- 2.11.7. гарсан шийдвэрийн агуулга.

2.12. Хуралдаан тус бүрээс дараах материалыг бүрдүүлэн, зөвлөлийн үйл ажиллагааны баримт бичигт хавсаргана.

- 2.12.1. хуралдааны хөтөлбөр;
- 2.12.2. хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудалтай холбогдсон материалын эх хувь;
- 2.12.3. хуралдааны явцын дэлгэрэнгүй тэмдэглэлийн эх хувь;
- 2.12.4. хуралдаанаас гарсан шийдвэр.

Гурав. Зөвлөлийн бүрэн эрх, үүрэг

3.1. Зөвлөл нь “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 17 дугаар зүйлд заасан бүрэн эрх, 27, 30 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх

4.1. Зөвлөлийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 4.1.1. зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг товлох, даргалах;
- 4.1.2 зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

- 4.1.3. зөвлөлийн гишүүдэд үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих;
- 4.1.4. шаардлагатай тохиолдолд зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

4.2. Зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 4.2.1. зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санаачлах, хэлэлцүүлэх;
- 4.2.2. хариуцсан байгууллага, нэгтгэл, ангиудад зөвлөлийн хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлж буй байдал, үр дүнд хяналт тавих;
- 4.2.3. зөвлөлийн даргын өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, хариуцсан байгууллага, чиглэлийн дагуу зөвлөлд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримтыг гаргаж өгөх;
- 4.2.4. зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгөх, төлөвлөгөө, тайлантай танилцах, зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах;
- 4.2.5. зөвлөлийн нарийн бичгийн даргатай үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох зорилгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг өөрийн байгууллагын холбогдох албан хаагчаар хариуцуулан гүйцэтгүүлэх;
- 4.2.6. байгууллагынхаа дотоодод болон эрхлэх асуудлын хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлан хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг улирал, хагас, бүтэн жилээр гарган зөвлөлд ирүүлэх.

4.3. Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр хүргүүлж болно.

Тав. Зөвлөлийн нарийн бичгийн дарга

5.1. Зөвлөлийн үйл ажиллагааг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулна.

5.2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 5.2.1. Зөвлөлийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ээлжит хуралдааны хуваарийг боловсруулан зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 5.2.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаал, зөвлөлийн шийдвэрийг холбогдох албан тушаалтан, харьяа агентлаг, аж ахуйн нэгж байгууллагуудад хэрэгжүүлж байгаа байдалд гишүүдийн хамт хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;
- 5.2.3. зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик, тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас

- гаргуулах, нэгтгэх, судалгаа, дүн шинжилгээ хийх, дүнг зөвлөлийн хуралдаан болон яамны удирдлагад танилцуулах;
- 5.2.4. зөрчлийн шалтгаан, нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах, дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах;
 - 5.2.5. зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, шийдвэр, зөвлөмж, албан даалгаврын төсөл боловсруулах;
 - 5.2.6. зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг боловсруулж, зөвлөлийн даргаар батлуулах;
 - 5.2.7. зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
 - 5.2.8. хуралдааны тэмдэглэл, шийдвэр, бусад холбогдох материалыг ажлын 3 хоногт багтаан албажуулах;
 - 5.2.9. зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;
 - 5.2.10. салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, уялдуулан зохицуулж дэмжлэг үзүүлэх;
 - 5.2.11. гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журмыг бэхжүүлэх, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтран зохион байгуулах;
 - 5.2.12. улирал бүрийн эхний сарын 10-ны дотор зөвлөлийн болон салбар зөвлөлүүдийн өмнөх улирлын, 07 дугаар сарын 10-ны дотор хагас жилийн, 01 дүгээр сарын 10-ны дотор жилийн үйл ажиллагааны тайланг нэгтгэж, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлэх;

Зургаа. Бусад

6.1. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тухайн жилийн Батлан хамгаалахын сайдын төсөвт тусгасан зардлаас санхүүжүүлнэ.

----oOo----